



**НИЙСЛЭЛИЙН
АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/114

Улаанбаатар хот

Биеийн тамир, спортын хамтлаг
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нийт ажиллагсдын бие бялдрыг эрүүлжүүлэн идэвхжүүлэх зорилгоор байгууллагын дэргэдэх Биеийн тамир, спортын хамтлагийг байгуулж, дүрмийг хавсралтаар баталсугай.

2. Байгууллагын биеийн тамир, спортын хамтлагийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Хамтлагийн ахлагч:	Г.Даваажаргал	Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсийн дарга
Хамтлагийн гишүүд:	Э.Цогзолмаа	Төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт хариуцсан мэргэжилтэн
	Э.Батцэцэг	Түлшний бодлогын хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн
	Э.Энх-Амгалан	Агаар бохирдуулах суурин эх үүсвэр хариуцсан мэргэжилтэн
	С.Алтансүх	Оператор, техникч
	У.Жаргалбаатар	Оператор, техникч
Нарийн бичгийн дарга:	Б.Оюунгэрэл	Диспетчер

3. Биеийн тамир, спортын хамтлаг нь ажиллагсдыг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллүүлэх төлөвлөгөө боловсруулан, спортын тэмцээн уралдаан зохион байгуулан ажиллахыг Хамтлагийн ахлагч /Г.Даваажаргал/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, Биеийн тамир, спортын хамтлагийг идэвхжүүлэн ажиллахыг Захиргааны хэлтэс /О.Алтангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ




Ц.ЦОЛМОН

1119282481-5290031

1150500239

Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх
газрын даргын 2020 оны 10 дугаар сарын
13-ны өдрийн АМТ дугаар тушаалын хавсралт



БАЙГУУЛЛАГЫН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ХАМТЛАГИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Биеийн тамир, спортын хамтлаг нь /цаашид “Хамтлаг” гэх/ байгууллагад биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар явуулах төлөвлөгөөг боловсруулан, шийдвэрийг хэрэгжүүлэх биеийн тамир, спортын нэгж мөн.

1.1. Хамтлагийн үндсэн зорилго нь ажилтан, албан хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх, оюун санаа, эрүүл мэндийг бэхжүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх хэрэгцээг төлөвшүүлэх үндсэн дээр байгууллагын хүний хөгжлийг дээшлүүлэн хамт олныг бүрэлдүүлэх, нийтийн биеийн тамир идэвхтэй хөдөлгөөнийг эрүүл аж төрөх ёсны салшгүй хэсэг болгох замаар спортын материаллаг баазыг нэмэгдүүлэхэд оршино.

1.2. Хамтлаг нь үйл ажиллагаандаа Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, бусад хамаарал бүхий хууль тогтоомж, шийдвэрүүдийг удирдлага болгоно.

1.3. Хамтлаг нь үүрэг зорилгоо хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байх бүрэлдэхүүнтэй байх бөгөөд уг бүрэлдэхүүнийг газрын даргын шийдвэрээр баталгаажуулна.

1.4. Хамтлаг нь байгууллагын дүрэм, журамд нийцүүлэн газрын тэмдэг, туг, логог хэрэглэнэ.

Хоёр. Удирдлага, бүтэц зохион байгуулалт

2.1. Хамтлаг нь газрын даргын баталсан бүрэлдэхүүнээр ажиллаж, байгууллагын үйл ажиллагаатай ажлаа нийцүүлэн ажиллана.

2.2. Хамтлагийн ахлагч нь үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, бүрэн эрхийг хэрэгжүүлэн ажиллахын зэрэгцээ газрын удирдлага, хамт олондоо тайлан тавина.

2.3. Хамтлаг нь байгууллагын биеийн тамир, спортын арга хэмжээнд зориулан олгосон төсвийн хөрөнгө, хандив бусад орлогын эх үүсвэрийг зарцуулна.

Гурав. Биеийн тамир, спортын хамтлагийн үүрэг

Хамтлаг нь өөрийн зорилгодоо нийцүүлэн дор дурьдсан үүргийг хүлээнэ.

3.1. Биеийн тамир, спортын талаар гаргасан төр засгийн бодлого, шийдвэрийг хамт олны дунд хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих.

3.2. Спортын уралдаан тэмцээн болон биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ажлын арга зүйн нэгдсэн удирдлагаар хангах, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг нь тооцох.

3.3. Ажиллагсдын биеийн тамир, спортоор хичээллэх болон бие бялдарын түвшин тогтоох сорил авах, эрүүл мэндийн хяналт тавих, нөхөн сэргээх зэрэг ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллах.

3.4. Биеийн тамир, спортын байгууллагаас явуулж буй хурал зөвлөгөөн, сургалт, онол практик, эрдэм шинжилгээний хуралд оролцох, зохион байгуулах.

3.5. Биеийн тамир, спортын болон эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллах, ажиллагсдын дунд биеийн тамир, чийрэгжүүлэлтийн ач холбогдлын талаар зөвлөгөө өгөх, сурталчлах, дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулах.

Дөрөв. Хамтлагийн эрх

4.1. Байгууллагын ажиллагсдын оюун санаа, бие бялдар, эрүүл мэндийг бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх хэрэгцээг төлөвшүүлэн хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардалагатай хэрэгсэл, материал авах зардлыг байгууллагын төсөвт суулган батлуулах.

4.2. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үйлст тодорхой хувь нэмэр оруулсан, спортын өндөр амжилт гаргасан ажилтан, албан хаагчийг дээд байгууллагын шагналд тодорхойлох.

4.3. Хамтлагийн биеийн тамир, спортын уралдаан тэмцээний заавар, журам, төлөвлөгөө, арга зүйн удирдамж зэргийг гарган зохион байгуулах.

4.4. Хамтлагийн ажлын талаарх бүртгэл, судалгааг хөтөлж, байгууллагын /БТС/ статистик тайлан мэдээг гаргах, нэгтгэж дүн шинжилгээ хийх.

4.5. Хамтлагийн эдийн засгийн чадвархийг сайжруулах зорилгоор байгууллагын төсвөөс хуваарилсан хөрөнгө, хамтлагийн үйл ажиллагааг дэмжигч дотоод гадаадын байгууллага, иргэдийн хандив тусламж авах, төслийн санхүүжилт, Монгол Улын хуулиар хориглоогүй бусад эх үүсвэр зэргээр санхүүжих.

Тав. Хариуцлага

5.1. Хамтлагийн тухайн жилийн үйл ажиллагаанд зарцуулагдах санхүү, төсвийг төсөвтөө тусгаагүй тохиолдолд дээд газрын захирамж, шийдвэрийг хэрэгжүүлээгүйд тооцно.

5.2. Спортын үйл ажиллагааг байгууллагадаа зохион байгуулаагүй, тухайн жилийн ажлын үр дүн, тайлан мэдээг хугацаанд нь Нийслэлийн Спортын хороонд явуулаагүй болон Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан заалтуудыг хэрэгжүүлээгүй тохиолдолд хуулийн дагуу хариуцлага тооцно.